



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/81

Арвайхээр

**Үнэлгээний хорооны нарийн бичгийн
дарга нөхөн томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн Ц.Оюун 2019 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс тэтгэвэр тогтоолгох насанд хүрч ажлаас чөлөөлөгдсөн тул Арвайхээр суманд зам цэвэрлэгээний авто машин нийлүүлэгчийг сонгон шалгаруулах, Залуучуудын усан спортын цогцолборын барилга угсралтын ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээ, Хархорин, Хужирт сумдын 75 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээ, Нарийнтээл сумын 240 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний үнэлгээний хорооны нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлж, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Б.Пүрэвсүрэнг үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар нөхөн томилсугай.

2.Шинээр томилогдсон албан хаагчийг өдөр тутмын удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж архив-бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100192